

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ



1995 оны 12 дугаар
сарын 07 өдөр

Дугаар 06/256

Улаанбаатар
 хот

Бараа, түүхий эдийн төв биржийг
татан буулгаж, хувьчлах тухай

1. Улаанбаатар хотын Бараа, түүхий эдийн төв биржийг татан буулгаж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Скорпион" корпорацийн харьяалалд 1995 оны 12 дугаар сарын 01-нээс шилжүүлсүгэй.

2. Бараа, түүхий эдийн төв биржийн үндсэн хөрөнгийн, төрийн өмчид хамарагдах хэсгийг хувьчилж бэлэн мөнгөөр худалдахыг Нийслэлийн өмч хувьчлалын комисс /Л.Ойдовсамбуу/-т даалгасугай.

3. Бараа, түүхий эдийн төв биржийг анх байгуулагдахад Нийслэлийн өмч хувьчлалын комиссоос олгосон 350.0 мянган төгрөгийг энэ онд багтаан төлөхийг тус биржийн захирал Л.Сүхэд даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 7 дугаар сарын 04-ний 204 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БАГААНД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БААСАНЖАВ

Ц.БААСАНЖАВ